



2011 оны 10 сарын 06 өдөр Төрийн ордон, Улаанбаатар хот

**АУДИТЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“5.Төсвийн байгууллага, түүнчлэн төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын санхүүгийн тайлангийн болон гүйцэтгэлийн аудит хийхэд энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт хамаарахгүй.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Компанийн тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**